ТУЗ-ийн 2026 оны 02 р сарын 25 ны өдрийн 02 тоот тогтоолын хавсралт № 2

## ОРЛОГО, ҮР ДҮНГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

| | 2024 | 2025 | 2026 |
|---|---|---|---|
| **САНХҮҮГИЙН ОРЛОГО, сая төг** | **12,180** | **13,727** | **25,770** |
| Үр тариа, тэжээл | 2,340 | 1,503 | 4,818 |
| Гурил, хивэг | 7,562 | 11,119 | 20,442 |
| Бусад | 2,278 | 1,105 | 510 |
| **НИЙТ САНХҮҮГИЙН ОРЛОГО** | **12,180** | **13,727** | **25,770** |
| Борлуулсан бүтээгдэхүүний өртөг | 9,282 | 10,302 | 18,487 |
| Үр тариа, тэжээл | 2,774 | 976 | 2,600 |
| Гурил, хивэг | 5,810 | 8,171 | 15,471 |
| Бусад | 698 | 1,155 | 416 |
| **НИЙТ АШИГ** | **2,898** | **3,425** | **7,283** |
| Боловсон хүчний холбогдолтой зардал | 514 | 840 | 1,260 |
| Ерөнхий удирдлагын бусад зардал | 1,074 | 1,157 | 2,757 |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ЗАРДАЛ | 1,588 | 1,997 | 4,017 |
| **ЕРӨНХИЙ ҮЙЛ АЖ-НЫ ЦЭВЭР АШИГ** | **1,310** | **1,428** | **3,266** |
| Санхүүгийн зардал | 808 | 879 | 1,279 |
| Ердийн бус орлого зардал | 17 | 25 | 35 |
| **ТАТВАРЫН ӨМНӨХ ОРЛОГО** | **485** | **574** | **2,022** |
| Татварын зардал | 59 | 57 | 202 |
| **ТУХАЙН ҮЕИЙН ЦЭВЭР АШИГ/АЛДАГДАЛ** | **426** | **516** | **1,820** |

ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН ... ЗӨВЛӨЛ
АТА5488 ... 2034565

ТУЗ-ийн 2026 оны 02-р сарын 25-ны өдрийн
02... тоот тогтоолын хавсралт №3

**1. Газар тариалангийн үйлдвэрлэлийн охин компани**
**Алтан Хажир ХХК-ийн 2026 оны үйлдвэрлэлийн төлөвлөгөө**

| Мөнгөн зардал | 2024 | 2025 | 2026 |
|---|---|---|---|
| **Тариалалт, га** | **1,836** | **770** | **1,405** |
| Улаанбуудай | 1,657 | 708 | 1,266 |
| Бусад үр тариа | 129 | 62 | 139 |
| Ногоон тэжээл | 50 | | |
| ***Га-н ургац, цн*** | | | |
| Улаанбуудай | 16 | 20 | 30 |
| Бусад үр тариа | 11 | 11 | 15 |
| Ногоон тэжээл | 15 | 15 | |
| **Нийт ургац, цн** | **2,938** | **1,487** | **4,005** |
| Улаанбуудай | 2,652 | 1,416 | 3,797 |
| Бусад үр тариа | 137 | 71 | 208 |
| Ногоон тэжээл | **150** | **-** | **-** |

| | | | |
|---|---|---|---|
| Нийт уринш хийх талбай, га | 869 | 1,592 | 187 |
| Нэгжийн өртөг (мөнгөн зардлаар), 1 кг у | 686 | 619 | 617 |
| Ажилтнуудын тоо | 23 | 18 | 22 |

**2. Гурилын үйлдвэрлэлийн төлөвлөгөө**

| Бүтээгдэхүүн, тн | 2024 | 2025 | 2026 |
|---|---|---|---|
| Тээрэмдэх буудай, тн | **4,307** | **6,985** | **13,676** |
| 1-р ба дээд гурил, тн | 3,162 | 4,681 | 9,729 |
| 2,3-р гурил, тн | 78 | 279 | 580 |
| Бүхэл үрийн гурил, тн | 178 | 162 | 322 |
| Хивэг, тн | 889 | 1,863 | 3,045 |
| | | | |

| | | | |
|---|---|---|---|
| Худалдан авч үйлдвэрт нийлүүлсэн, тн | 4,269 | 7,925 | 16,900 |
| Ажилтаны тоо | 32 | 32 | 32 |

ТУЗ-ийн 2026 оны 02 р сарын 25-ны
өдрийн 02 тогтоолын хавсралт №4

ХӨВСГӨЛ АЛТ... ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

**Хөвсгөл Алтандуулга ХК-ийн 2026 оны нийт зардлын төсөв**

| Мөнгөн зардал | Төсөв |
|---|---|
| Газар тариалангийн зардал | 2,059,136,002 |
| Боловсруулах үйлдвэрлэлийн зардал | 15,471,000,000 |
| Борлуулалтын зардал | 441,288,375 |
| Ерөнхий удирдлагын зардал | 2,757,157,332 |
| Санхүүгийн зардал | 1,279,000,000 |
| Үндсэн хөрөнгийн худалдан авалт | 1,921,800,000 |
| ***Нийт зардал*** | ***23,929,381,708*** |

ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

ТУЗ-ийн 2026 оны 02-р сарын 25-ны өдрийн 02 тоот
тогтоолын хавсралт №5

**Хөвсгөл Алтандуулга ХК-ийн газар тариалангийн үйлдвэрлэлийн охин компани Алтан Хажир ХХК-ийн 2026 оны зардлын төсөв**

| Мөнгөн зардал | Төсөв |
|---|---|
| **Хувьсах зардал бүгд** | **1,377,457,652** |
| Шатахуун | 176,847,670 |
| Цалин, НДШ | 81,082,332 |
| Бордоо, ургамал хамгааллын бодис | 568,866,081 |
| Үр | 110,880,000 |
| Сэлбэг засвар үйлчилгээ, туршилт | 427,890,960 |
| Хүнс | 11,890,610 |
| ***Тогтмол зардал бүгд*** | **681,678,349** |
| Цалин, урамшуулал, НДШ | 506,335,637 |
| Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл | 6,600,000 |
| Газрын татвар хураамж | 8,562,712 |
| Зөвлөх үйлчилгээ | 40,000,000 |
| Программ хангамж | 2,100,000 |
| Цахилгаан холбооны зардал | 600,000 |
| Томилолтын зардал | 20,000,000 |
| Сургалтын зардал | 3,500,000 |
| Шатахуун | 30,000,000 |
| Арга хэмжээний зардал | 10,000,000 |
| Талбайн хамгаалалт | 17,500,000 |
| Хөрөнгө оруулалт | |
| Зээл, зээлийн хүү | 17,000,000 |
| Бусад | 19,480,000 |
| ***Зардал бүгд*** | **2,059,136,002** |

ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ
АТА5488 № 2034565

ТУЗ-ийн 2026 оны 02-р сарын 25-ны
өдрийн 22 тоот тогтоолын хавсралт №6

**Хөвсгөл Алтандуулга ХК-ийн гурилын үйлдвэрийн зардлын 2026 оны төсөв**

| Мөнгөн зардал | Төсөв |
|---|---|
| **Хувьсах зардал** | **23,207,700,752** |
| Буудай худалдан авах* | 22,105,666,450 |
| Сав баглаа боодол | 415,648,145 |
| Ажилтнуудын цалин НДШ | 236,611,685 |
| Цахилгаан | 259,811,472 |
| Бусад ашиглалтын зардал | 348,000 |
| Сэлбэг засвар | 115,655,000 |
| Ажилтнуудын хүнс | 44,000,000 |
| Шатахуун | 29,960,000 |
| **Тогтмол зардал** | **851,049,565** |
| Ажилтнуудын цалин, НДШ | 563,213,535 |
| Ашиглалтын Зардал | 100,414,800 |
| Тээвэр, шатахуун | 1,228,800 |
| Хангамжийн материал | 754,900 |
| Хөдөлмөр хамгааллын зардал | 17,000,000 |
| Сэлбэг зсвар | 9,000,000 |
| Элэгдэлийн зардал | 116,077,530 |
| Бусад | 43,360,000 |
| **Нийт мөнгөн зардал** | **24,058,750,317** |

| | |
|---|---|
| Нийт тээрэмдэх буудай, тн | 14,500 |
| * Худалдан авч үйлдвэрт нийлүүлсэн, тн | 16,900 |
| Ажилтаны тоо | 47 |

ТУЗ-ийн 2026 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 02
тоот тогтоолын хавсралт №7

ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

## Ерөнхий удирдлагын зардлын 2026 оны төсөв

| Зардлын зүйл | ЕУд | Туз | Бор | Нийт дүн |
|---|---|---|---|---|
| Цалин, урамшуулал, НДШ | 464,136,562 | 87,467,640 | 33,154,800 | 584,759,002 |
| Гэрээт ажил үйлчилгээ | 45,000,000 | | 667,485,695 | 712,485,695 |
| Зөвлөх үйлчилгээ,Маркетинг | 5,000,000 | | 100,000,000 | 105,000,000 |
| Аудитын зардал | 35,500,000 | | | 35,500,000 |
| Албан томилолтын зардал | 30,000,000 | 2,100,000 | | 32,100,000 |
| Сургалтын зардал | 3,000,000 | | | 3,000,000 |
| Ажиллагсдын ЭМ-ийн үзлэг | 6,000,000 | | | 6,000,000 |
| Арга хэмжээ/хурлын зардал | 36,000,000 | 7,037,000 | | 43,037,000 |
| Цахилгаан ба ашиглалтын бусад | 14,400,000 | | | 14,400,000 |
| Шатахуун | 50,000,000 | 18,000,000 | | 68,000,000 |
| Тээвэр | 600,000 | | 262,100,000 | 262,700,000 |
| Шимтгэл хураамжийн зардал | 2,010,000 | | | 2,010,000 |
| Бичиг хэргийн зардал | 2,790,000 | 283,740 | | 3,073,740 |
| Шуудан холбооны зардал | 3,990,000 | 1,320,000 | | 5,310,000 |
| Программ хангамжийн үйлчилгээ | 2,896,000 | | | 2,896,000 |
| Үл хөдлөх хөрөнгийн татвар | 18,002,000 | | | 18,002,000 |
| Үндсэн хөрөнгийн засвар, урсгал зардал | 20,000,000 | | | 20,000,000 |
| Элэгдэл, хорогдлын зардал | 56,493,894 | | | 56,493,894 |
| Зарын зардал | 960,000 | 800,000 | | 1,760,000 |
| Цайны зардал | 1,000,000 | 140,000 | | 1,140,000 |
| Хангамжийн материалын зардал | 12,000,000 | | | 12,000,000 |
| Гишүүнчлэлийн татвар | 3,200,000 | | | 3,200,000 |
| Хөрөнгийн биржийн үйлчилгээний зардал | 2,040,000 | | | 2,040,000 |
| Хандив тусламжийн зардал | 12,050,000 | | | 12,050,000 |
| Бусад | 12,000,000 | 4,200,000 | | 16,200,000 |
| **Дүн** | **839,068,456** | **121,348,380** | **1,062,740,495** | **2,023,157,332** |

ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА ХУВЬЦААТ КОМПАНИ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ АТА5488 2034565

ТУЗ-ийн 2026 оны 02 р сарын 25 -ны өдрийн 02 тоот тогтоолын хавсралт № 8

**2026 оны хөрөнгө оруулалтын төсөв**

| Нэгж | Төлөвлөсөн хөрөнгө оруулалт | Төсөв |
|---|---|---|
| ГҮ | Бэлэн бүтээгдэхүүний агуулах | 1,500,000,000 |
| | Поддон /200ш/ | 76,800,000 |
| | Сэрээт өргөгч | 65,000,000 |
| Үтрэм | Силосны хүлээн авахын цэвэрлэгээний төхөөрөмж | 280,000,000 |
| | НИЙТ | 1,921,800,000.00 |

“Хөвсгөл алтандуулга” ХК-ийн ТУЗ-ийн 2026 оны 02 сарын 25-ны өдрийн 03 тоот тогтоолын 02 дугаар хавсралт

## “ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА” ХУВЬЦААТ КОМПАНИ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛД ОРОЛЦОГЧДООС САНАЛ АВАХ ХУУДАС

Хувьцаа эзэмшигчдийн овог ........................ нэр ...........................
Регистерийн дугаар.........................................................................
Санал өгөх хувьцааны тоо .................
Үйлчилсэн / Үнэт цаасны компани / .....................................
“Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2026 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 11.00 цагт Хөвсгөл аймаг, Тариалан сум, Мандал баг, “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн байранд болно.

| № | Хэлэлцэх асуудал | Тухайн асуудлаар гарах шийдвэрийн төсөл | Зөвшөөрсөн | Түдгэлзсэн | Татгалзсан | Татгалзсан бол таны өгөх санал |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай | Тогтоол №01 | | | | |
| 2 | ТУЗ-ийн 2025 оны зардлын төсвийг батлах тухай | Тогтоол №02 | | | | |
| 3 | ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын тухай | Тогтоол №04 | | | | |

(Та саналын хуудсыг бөглөхдөө өөрийн сонгож буй хэсэг + тэмдгийг бичнэ үү)

Хувьцаа эзэмшигч..................................... Гарын үсэг

2026 оны 04 дүгээр сарын ....-ны өдөр

**Санал авах хуудсыг ашиглах санамж:** Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр ирж хуралд оролцох боломжгүй бол 2026 оны 04-р сарын 08-ны өдрийн 11.00 цагаас өмнө “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн УБ хот болон орон нутгийн байранд очиж, хурлын материалтай танилцан санал авах хуудсаар саналаа өгнө. Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэх бол тухайн хүндээ итгэмжлэл өгч нотариатаар батлагаажуулсан байна. Засварласан болон балласан санал авах хуудас нь хүчингүйд тооцогдоно.

“Хөвсгөл алтандуулга” ХК-ийн ТУЗ-ийн 2026 оны 02 сарын 25-ны өдрийн 03 тоот тогтоолын 03 дугаар хавсралт

# “ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА” ХУВЬЦААТ КОМПАНИ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛД ОРОЛЦОГЧДООС САНАЛ АВАХ ХУУДАС

Хувьцаа эзэмшигчдийн овог ........................ нэр ...........................
Регистерийн дугаар.......................................................................
Санал өгөх хувьцааны тоо .................
Кумулятив саналын тоо.......................
Үйлчилсэн / Үнэт цаасны компани / ......................................
“Хөвсгөл алтандуулга” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2026 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 11.00 цагт Хөвсгөл аймаг, Тариалан сум, Мандал баг, “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн байранд болно.

| | ТУЗ-Д НЭР ДЭВШИГЧДИЙН НЭРС | НЭР ДЭВШИГЧДЭД ӨГӨХ САНАЛЫН ТОО |
|---|---|---|
| | **Ердийн гишүүд:** | |
| 1 | | |
| 2 | | |
| 3 | | |
| 4 | | |
| 5 | | |
| 6 | | |
| 7 | | |
| 8 | | |
| 9 | | |
| | **Хараат бус гишүүд:** | |
| 1 | | |
| 2 | | |
| 3 | | |
| 4 | | |
| 5 | | |
| 6 | | |

Хувьцаа эзэмшигч..................................... Гарын үсэг

2026 оны 04 дүгээр сарын ....-ны өдөр

**Саналын хуудас бөглөх санамж:** ТУЗ-ийн гишүүдийг сонгох санал хураалтыг кумулятив аргаар хураана. Кумулятиваар аргаар таны санал өгөх эрхийн нийт тоо нь таны

эзэмшиж байгаа саналын эрхтэй энгийн хувьцааны тоог сонгогдох гишүүний тоогоор буюу 9-өөр үржүүлсэнтэй тэнцүү байна. **Жишээ нь:** та 100 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг гэвэл тус компанийн ТУЗ нь 9 гишүүнтэй байхад үүнээс 3 гишүүн нь хараат бус гишүүн байхаар тогтоосон тохиолдолд Хувьцаа эзэмшигч  эзэмшиж буй 100 ширхэг энгийн хувьцаа нь кумулятив аргаар санал өгөхөд нийт 900 саналын эрхтэй /100*9 гишүүн=900/ болох бөгөөд үүнээс 600 саналын эрхээрээ ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдох 6 хүртэл нэр дэвшигчид, 300 саналын эрхээрээ ТУЗ-ийн хараат бус гишүүнээр сонгогдох 3 хүртэл нэр дэвшигчид тус тус санал өгөх эрхтэй болно гэдгийг анхаарна уу.

# ХӨВСГӨЛ АЛТАНДУУЛГА ХК 2025 оны тайлан



# КОМПАНИЙН ХУРААНГУЙ ТАНИЛЦУУЛГА

| | “Хөвсгөл Алтандуулга” ХК |
|---|---|
| Улсын бүртгэлийн дугаар | 1710001001 |
| Регистрийн дугаар | 2034565 |
| Үүсгэн байгуулагдсан огноо | 1996.04.25 |
| Үйл ажиллагааны чиглэл | Үр тариа үйлдвэрлэл |
| | Гурил үйлдвэрлэл |
| | Малын тэжээлийн үйлдвэрлэл |
| | Хүнсний ногоо тариалах |
| | Гадаад дотоод худалдаа |
| | Малын аж ахуй |
| | Хууль тогтоомжоор хориглоогүй бусад төрлийн үйл ажиллагаа |
| Хувь нийлүүлсэн хөрөнгө | 157,342 мянган төгрөг |
| Компанийн хаяг | Хөвсгөл, Тариалан, Мандал |
| Холбоо барих утас | 70386030, 77116031 |
| Хувьцаа эзэмшигчдийн тоо | 500 хувьцаа эзэмшигчидтэй |
| | (2025.12.31 байдлаар) |

# 2025 оны үйл ажиллагааны гүйцэтгэл

- **Газар тариалангийн үйлдвэрлэл**

- 2025 онд өөрсдийн санхүүгийн боломжид тулгуурлан нийт 1204 га-д тариалалт хийж, хураан авах ургацын хэмжээг нэмэгдүүлэх, бүтээгдхүүний чанарыг сайжруулахад анхаарав. 1204 га талбайгаас улаан буудайн 4 сортын үрээр 1102,2 га-д, халтар арвай 25 га , ногоон тэжээл 56, шар буурцаг 20,8 га-д тус тус тариалав.
- Тариалалтанд шаардлагатай үрийн буудай 516 тн-ыг ХААК -иас гэрээ хийн авсан ба элит ангилалын үрийн буудай 3 сорт 56 тн, дотоодын 3 сортын 460 тн үрийг авав.

| Таримлын төрөл | Тариалалт /га/ | Ургац /тн/ |
|---|---|---|
| Улаанбуудай | 1102,2 | 1250 |
| Халтар арвай | 25 | 10 |
| Тэжээлийн ургамал | 55 | 70 |
| Шар буурцаг | 20,8 | 0 |
| Нийт | 1204 | 1330 |






# 2025 оны үйл ажиллагааны гүйцэтгэл

## • Боловсруулах үйлдвэрлэлт

- 2025 онд нийт **7,341.92** тн түүхий эдийг боловсруулах үйлдвэрт хүлээн авч ус дулаанаар боловруулах болон цэвэрлэж, эцсийн бүтээгдэхүүн үйлдэрлэв.
- Нийт 5 нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэснээс

| Дээд гурил | 1-р гурил | 3-р гурил | Бүхэл үрийн гурил | Хивэг тэжээл |
|---|---|---|---|---|
| 14% | 54,6% | 4,39% | 1,87% | 20,07% |

- Нийт тээрэмдсэн улаанбудайн 79.9% нь гурил, 20,1% тэжээлийн хивэг үйлдвэрлэсэн ба ТЭМ-ийн хангалтын 10,2 хувийг өөрийн газар тариалангаас, 33,1 хувийг ААН, иргэнээс, 56,7 хувийг ХААК-аас тус тус худалдан авсан байна.

Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, 5-н жилийн харьцуулалт




| | 2021 | 2022 | 2023 | 2024 | 2025 |
|---|---|---|---|---|---|
| Тээрэмдсэн буудай | 8,134 | 8,611 | 4,748 | 4330.7 | 7,342 |
| 1-р ба дээд гурил | 5,346 | 5,895 | 3,222 | 3091.6 | 5,095 |
| 2,3-р гурил | 311 | 200 | 359 | 180.6 | 322.6 |
| Бүхэл үрийн гурил | 85 | 109 | 101 | 168.1 | 137 |
| Хивэг | 2,301 | 2,294 | 1,066 | 890.4 | 1,473.6 |
| Хаягдал | 91 | 114 | | | 308 |

## ЛАБОРАТОРИ

- Энэ онд иргэн аж ахуйн нэгжээс хүлээн авсан улаан буудайн 410 сорьцод давхардсан тоогоор 7 үзүүлэлтээр, үйлдвэрлэлийн шат дамжлагын хяналтаар улаан буудайд 7 үзүүлэлтээр 3047 сорьцод, бэлэн бүтээгдэхүүний хяналт шинжилгээг давхардсан тоогоор 5 үзүүлэлтээр 7680 сорьцод цаг хугацаанд нь батлагдсан стандарт арга аргачлалын дагуу халдвар хамгаалал аюулгүй ажиллагааны дэглэмийг нарийн баримтлан чанартай хийж гүйцэтгэн сорилтын дүн хариуг хугацаанд нь гарган ажиллаж байна. Мөн тарих үрийн чанар, хорио цээрийн шинжилгээг гүйцэтгэсэн.
- Намрын ургац хураалтаар хүлээн авсан түүхий эдийн чанарын үзүүлэлтийг хадгалалтын орчинтой зурагжуулав.
- MNS ISO/IEC 17025:2018 Дагуу лаборатори хооронд харьцуулсан шинжилгээг Хөвсгөл аймгийн Стандарт хэмжил зүйн газрын сорилтын лабораторитой тарих үрийн чанар болон бүхэл үрийн гурилын чанарыг тодорхойлох үзүүлэлтээр үр дүнг тооцон ажиллав.



# Inframatic 9500

Inframatic 9500 төхөөрөмж аван өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглаж. байна





Inframatic 9500 нь боловсруулах үйлдвэрийн хэрэгцээнд зориулан тусгайлан бүтээгдсэн төхөөрөмж юм. Энэ нь бүхэл үр тариа, тослог ургамал, буурцагт ургамал болон шошыг чийгшил, уураг, тос зэрэг үзүүлэлтээр 1 минутаас бага хугацаанд шинжилнэ.

Энэхүү төхөөрөмжийг хэрэглэж эхэлснээр шинжилгээнд зарцуулах цаг үлэмж багасч, мөн үзүүлэлт өндөр нарийвчлалтай гарч байгаа нь ажлыг бүтээмжийг нэмэгдүүлж байна.

## Газар тариалангийн борлуулалт

- Газар тариалангаас авч буй тавaарын буудайн ургацыг өөрийн гурилын үйлдвэрт нийлүүлдэг бол газар тариалангийн бусад ургамлын борлуулалтыг Алтанхажир ХХК өөрөө бие даан хийдэг.
- Мөнгөн хөрөнгийн дутагдлыг нөхөх зорилгоор жил бүр тодорхой га талбайг ойр орчмын ААН, иргэдэд түрээсэлдэг ба 2025 онд түрээсийн нийт орлого **227,287,004** сая төгрөгт хүрсэн байна.

### Борлуулалтын орлого, оноор




### Борлуулалтын орлого, сая төгрөгөөр



# Хүний нөөц



2025 оны жилийн эцсийн байдлаар “Хөвсгөл Алтандуулга” ХК нь нийт 7 нэгжийн 60 ажилтантайгаар хэвийн үйл ажиллагаагаа явуулж байна.

Боловсруулах үйлдвэр оны эцсээр 2 ээлж болон ажиллаж байгаатай холбогдуулан шаардлагатай хүний нөөцийн бүрдүүлэлт хийж орон нутгийн 20 иргэнийг шинээр ажлын байраар хангаж, дагалдуулан чадваржуулж ажиллаж байна. Мөн 2 мэргэжилтнийг орон сууцаар ханган байршуулан ажиллаж, тус онд нийт 22 ажилтныг байнгын ажлын байраар ханган орон тоогоо нэмэгдүүлсэн бол гавьяаныхаа амралтад гарсан-1, өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн-5, нийт 6 ажилтан ажлаас чөлөөлөгдсөн байна.

Ажилтнуудын бүтэц, хуваарилалт нь байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагааг жигд, тасралтгүй хангах чиглэлд зохион байгуулагдсан бөгөөд хүний нөөцийн тогтвортой байдлыг хадгалах, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэхэд анхааран ажиллаж байна.

# Бүтэц, орон тоо












# Архив,
# бичиг хэрэг

- 2023, 2024, 2025 оны бүх баримт бичгийг архивын журмын дагуу ангилан дугаарлаж, цахим хувилбарыг бэлтгэн сканнердаж, нэгдсэн бүртгэлд оруулан архивлав.

- Архивын бүртгэл шинэчлэгдэж, 2026 оны ажилд ашиглах нөхцөл бүрдсэн.



- Албан бичгүүдийг тухай бүр гаргаж, дугаарлан холбогдох ажилтнууд болон байгууллагуудад танилцуулах ажил тогтмол хийгдэв.

- Архивын өрөөний эмх цэгцийг хангаж, цэвэрлэгээ хийн, “Архивын журам”-ын холбогдох нэгжийн удирдлагуудад танилцуулав.

- “Ажлын цаг бүртгэл, ашиглалтын журам”, “Сургалт хөгжлийн журам”, “Албан томилолтын журам” гэсэн 3 журам боловсруулан батлуулж, хэрэгжүүлж эхлээд байна.

- Сум орон нутгийн засаг захиргааны ажилтнуудтай уялдаа холбоотой ажиллаж, тухай бүр шаардлагатай мэдээ мэдээлэл, тайлан гаргаж явуулан хамтран ажиллаж байна.

# Хүний нөөцийн мэдээллийн сан

- 2024, 2025 оны ажилтнуудын хувийн мэдээллийн санг шинэчлэх ажлыг эхлүүлж, ажилтны судалгаа, бүрдүүлэлтийн үйл явц явагдаж байна

- Шинэчлэлтийн хүрээнд төрийн албан ёсны мэдээлэлтэй уялдуулах, цахим санг сайжруулах зорилт тавин ажиллаж байна.

# Соёл, спортын үйл ажиллагаа

- “Хөвсгөл Алтандуулга” ХК болон “Алтан Хажир” ХХК-ийн нэрэмжит волейболын тэмцээнийг нээлттэй хэлбэрээр амжилттай зохион байгуулав. Уг тэмцээнд нийт 23 багийн 180 гаруй тамирчин оролцож, хамт олны уялдаа холбоо, хамтын ажиллагааг бэхжүүлэв.

- Намрын ургац хураалт эхлэхээс өмнө ажлын алжаал ядаргаагаа тайлан агаарт гарч 1 хоног амарлаа.

- Жилийн эцсийн ажил үүргээ дүгнэн “Шинэ жилийн цэнгүүн”-ийг Хөвсгөл аймгийн төв Мөрөн суманд амжилтай зохион байгуулж, оны шилдэгүүдээ тодруулан, ололт амжилтаа хуваалцлаа.



# Сургалт, мэдээллийн үйл ажиллагаа

## 01

- “Хөвсгөл Алтандуулга” ХК, “Алтан Хажир” ХХК-ийн ажилчдад зориулсан 8 цагийн ХАБЭА-н сургалт зохион байгуулж, оролцогчдоос анхан шатны мэдлэгийн шалгалт авч, бүртгэлжүүлсэн. Сургалтад нийт 42 ажилтан хамрагдаж, мэдлэгийн шалгалтыг амжилттай хамгаалсан.

## 02

- Компанийн дотоод журам болон Хөдөлмөрийн тухай хуулийн хэсгээс нийт ажилчдад мэдээлэл, сургалт зохион байгуулсан. Нийт 30 ажилтан хамрагдсан.

## 03

- Урт хугацааны баярын амралт болон цаашдын үйл ажиллагааны чиглэл, дотоод асуудлын талаар хэлэлцэх нийт ажилчдын хурал зарлан, зарим асуудлуудын талаар оновчтой шийдэлд хүрсэн.

# Нийгмийн хариуцлага



Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг угтан компанийн 38 ажилтны 71 хүүхдэд зориулан 4 насны ангиллаар гарын бэлэг бэлтгэн хүргүүлэв.

Энэхүү үйл ажиллагаа нь ажилчдын сэтгэл ханамж, байгууллагын нийгмийн хариуцлагыг дэмжсэн чухал үйл явдал болов.



Мөн тус өдрийг тохиолдуулан сумын зорилтот бүлгийн 1 хүүхдэд гарын бэлэг бэлтгэн, хүндэтгэл үзүүлэв.




“Жижиг хайрцаг том сэтгэл” орон нутгаас зарласан аяны хүрээнд нийт ажилтнууд 2,000,000 /хоёр сая/ орчим төгрөгийн эд зүйл, хичээлийн хэрэгсэл, тоглоом, хувцас цуглуулан хандивлалаа.

Ажилтнуудын сургалт, хувийн хөгжилд дэмжлэг үзүүлэх, ар гэрийн гачигдал, хүндрэлийн үед туслалцаа үзүүлэх зэрэг бодлогыг компанийн дотоод журамд нийцүүлэн шуурхай, уян хатан идэвхтэй хэрэгжүүлэн хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах чиглэлд анхаарч ажиллаж байна.



# Дүгнэлт

2025 онд Хүний нөөц, бичиг хэргийн алба нь баримт бичгийн хөтлөлт, хүний нөөцийн мэдээллийн сангийн шинэчлэл, ажилтны сургалт, хамт олны уялдаа холбоо болон нийгмийн арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж, байгууллагын дотоод үйл ажиллагааг тогтвортой, үр ашигтай явуулахыг зорин ажиллалаа.

Цаашид тухайн жилд хийсэн ажлын үр дүнг бататган, хүний нөөцийн чадавх, цахимжуулалт, ажилтны сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх, ажлын гүйцэтгэлийг үнэлэх чиглэлээр шат дараалсан арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллахаар төлөвлөж байна.

# Аж ахуй






Байгууллагын хашааны шар өвс, хогийг цэвэрлэж, газрын шороог зөөлрүүлэн тэгшилж, орчны өнгө үзэмжийг сайжруулах тохижилтын ажлыг хийж гүйцэтгэв.

Хаврын улиралд мод, бут сөөгийн цэнэг усалгаа хийж мөн байгууллагын хашаа, орчны талбайд шинээр мод тарьж, ногоон орчин бүрдүүлэхэд анхааран ажиллалав.

Байгууллагын хашаа болон орчны тохижилт, ногоон байгууламж нэмэгдүүлэх зорилгоор хүнсний ногоо тарьж, газрын бэлтгэл, үрсэлгээ, усалгаа, арчилгааны ажлыг хийв.

Байгууллагын удирдлагын байрны дотор болон гадна талыг угааж цэвэрлэх, цонх, хаалга, хана, шал зэрэг бүх хэсэгт ерөнхий цэвэрлэгээ хийж, ажлын орчны эмх цэгц, цэвэр байдлыг ханган ажиллав.

Байгууллагын хашаа, агуулах, гадна орчны бүсэд хортон шавьж, мэрэгчдийн эсрэг ариутгал, шавьж устгалын ажлыг хийж, халдвар хамгааллын нөхцөлийг сайжрууллав.













# Дүгнэлт

2025 онд аж ахуйн нэгж нь компанийн өдөр тутмын үйл ажиллагааг дэмжих, ажлын орчны тохижилт, цэвэрлэгээ, ариутгал, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, байгууллагын эзэмшлийн эд хөрөнгийн ашиглалт, засвар үйлчилгээг хэвийн байлгах, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах чиглэлээр төлөвлөгөөт ажлуудыг үе шаттайгаар зохион байгуулж, амжилттай хэрэгжүүлэн ажиллалаа.

Тайлант хугацаанд нийт 9 төрлийн ажил, арга хэмжээг тогтмол, уялдаа холбоотойгоор зохион байгуулсны үр дүнд байгууллагын гадна, дотор орчны цэвэр, тохилог байдал сайжирч, ажилтнуудын ажлын таатай нөхцөл бүрдэн, үйл ажиллагааны хэвийн тасралтгүй байдлыг хангахад бодитой хувь нэмэр оруулсан болно.

Цаашид улирлын онцлогт нийцүүлэн ногоон байгууламжийг өргөтгөх, байгууллагын эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах, ажлын байрыг эрүүл, аюулгүй, цэгцтэй орчинд байлгах зорилтыг баримтлан, холбогдох ажлуудыг төлөвлөгөөний дагуу шат дараатайгаар хэрэгжүүлэн ажиллахаар төлөвлөж байна.

# Хөдөлмөрийн аюулгүй байдал, Эрүүл ахуйн алба





2025 онд байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагааны аюулгүй, тогтвортой үргэлжлэх нөхцөлийг бүрдүүлэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр хууль тогтоомж, холбогдох дүрэм, журам, стандартын дагуу ажлуудыг зохион байгуулж, хэрэгжилтийг хангахаар ажиллалаа.

ХАБЭА-н зохион байгуулалт нь эрсдлийг бууруулах, ажилтнуудын эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, үйлдвэрлэлийн осол, эрсдэл, мэргэжлээс шалтгаалах өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны сахилга, хариуцлагыг дээшлүүлэхэд анхаарч ажилласан.







- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д заасны дагуу байгууллагын нийт ажилчдыг хамруулсан ХАБЭА-н сургалтыг төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, ажилтнуудад хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн талаарх хууль, дүрэм, журам, зааварчилгааг танилцуулан, үйлдвэрлэлийн осол, осол дөхсөн тохиолдол, мэргэжлээс шалтгаалах өвчлөлөөс урьдчилан сэргийлэх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллалаа.

- Боловсруулах үйлдвэрийн өдөр тутмын болон төлөвлөгөөт их цэвэрлэгээний ажлын гүйцэтгэлд тогтмол хяналт тавин, үйлдвэрийн эрүүл ахуйн шаардлага, стандартын хэрэгжилтийг хангах нөхцөлийг бүрдүүлэв.

Буцаалтаар ирсэн гурилыг тусгайлан ялган хадгалж, холбогдох журмын дагуу дээж авч лабораторийн шинжилгээнд хамруулан, шинжилгээний үр дүнг үндэслэн дахин ашиглахгүй байх, устгалд шилжүүлэх шийдвэрийг гаргаж, эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлын эрсдэл үүсэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэв

★★★★★

- Бүтээгдэхүүн ачих, тээвэрлэх үеийн эрүүл ахуйн шаардлагыг хангах, тоосжилт, бохирдлоос сэргийлэх, ачилтын бүсийн эмх цэгцийг сахиулах, өргөх, зөөх ажлын аюулгүй ажиллагааны зааварчилгаа мөрдүүлэх, хамгаалах хувцас, хэрэгслийн хэрэглээнд хяналт тавьж, үйлдвэрлэлийн осол, эрсдэл үүсэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэв.



★★★★★

- Шинээр ажилд орсон болон бусад ажилчдад хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны урьдчилсан болон давтан зааварчилгааг тогтмол өгч, ХАБЭА-тай холбоотой хууль, дүрэм, журам, зааварчилгааг танилцуулах сургалтыг зохион байгуулсан.
- Ажлын байран дахь хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, осол, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор драгер сорил, шалгалтыг журмын дагуу тогтмол хэрэгжүүлж үр дүнг бүртгэн хяналт тавьж ажилласан.

★★★★★

Хөдөлмөрийн аюулгүй байдал, Эрүүл ахуйн тухай хуулийн 15 дугаар зүйлд заасны дагуу нийт ажилчдад хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэглэлийг захиалан олгож, шаардлагатай зааварчилгааг өгч ажиллав.



# Дүгнэлт

Эдгээр арга хэмжээ нь хөдөлмөрийн аюулгүй байдлын сахилга, хариуцлагыг дээшлүүлэх, үйлдвэрлэлийн осол, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ажилтнуудын эрүүл, аюулгүй орчныг баталгаажуулахад чухал хувь нэмэр оруулсан.

Цаашид ХАБЭА-н тогтолцоог тогтмол сайжруулж, сургалт, хяналт, хамгаалалтын арга хэмжээг улирлын онцлогт тохируулан үргэлжлүүлэх, байгууллагын эрсдлийн үнэлгээг хийлгэж, эрсдлийн эсрэг арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллахаар төлөвлөж байна.

# Боловсруулах үйлдвэр

2025 онд нийт 7,342 тн түүхий эдийг боловсруулах үйлдвэрт хүлээн авч ус дулаанаар боловруулах болон цэвэрлэх,эцсийн бүтээгдэхүүн болгох дамжлагийг 14хүний дундаж орон тоотой хийж гүйцэтгэсэн байна. Нийт 5 нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлснээс:

- дээд гурил - 14%
- 1-р гурил - 54,6%
- 2,3-р гурил - 4,39%
- Хивэг тэжээл – 20,07%
- Бүхэл үрийн гурил – 1,87 % гарцтай байна

| Үйлдвэрлэсэн сар | Дээд гурил | % | 1-р гурил | % | Хивэг | % | 3-р гурил | % | Бүхэл үр | | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 12525 | | 144,125 | | 60000 | | 10475 | | 1350 | | 228,475 |
| 2 | 77,577 | | 165,495 | | 70325 | | 29325 | | 1300 | | 344,022 |
| 3 | | | | | | | | | | | |
| 4 | 68,200 | | 83525 | | 58475 | | 21550 | | 23136 | | 254,886 |
| 5 | 53,150 | | 164850 | | 37275 | | 9900 | | 20300 | | 285,475 |
| 6 | 97,650 | | 386,900 | | 148525 | | 36250 | | 34355 | | 703,680 |
| 7 | 35575 | | 172,425 | | 61225 | | 18800 | | | | 288,025 |
| 8 | 109675 | | 344,805 | | 117725 | | 38300 | | 15250 | | 625,755 |
| 9 | 194025 | | 593,360 | | 212425 | | 60325 | | | | 1,060,135 |
| 10 | 81525 | | 551995 | | 195000 | | 43125 | | | | 871,645 |
| 11 | 83450 | | 597692 | | 155175 | | 33825 | | 21575 | | 891,717 |
| 12 | 267606 | | 808887 | | 357500 | | 20675 | | 19729 | | 1,474,397 |
| Нийт дүн | 1,080,958 | 14% | 4,014,059 | 54% | 1,473,650 | 20% | 322550 | 4,3% | 168140 | 2,2% | 7,341,919.75 |





- ✓ Дээд гурилын босоо агуулахыг 5 тонн багтаамжтай байсныг 10 тонн болгож нэмж өндөрлөв.
- ✓ Савлагааны хэсгийн хаалга шинээр хийж угсрав.
- ✓ Агуулахын хаалга хийж гүйцэтгэв.
- ✓ Гурилын норм болгон тоосжилт ихтэй байсан тул эсгийгээр жийргэвч хийв.





Боловсруулах үйлдвэрийн гадаад сэлбэг захиалга,болон үтрэмийн буудай хүлээн авах хэсгийн цэвэрлэгээг сайжруулах улаанбуудайн стандарт MNS;0097:2010 нийцсэн түүхий эдийг үйлдвэрт шилжүүлэх зорилгоор БНХАУ-с TXZS 200\250 маркын улаан буудай цэвэрлэх тоног төхөөрөмж болон боловсруулах үйлдвэрийн сэлбэг захиалан суурьлуулж хэвийн ажиллагаанд оруулав.

Мөн үтрэмийн силос хэсгийн түүхий эд хүлээж авах хэсгийн буудай цэвэрлэх байгууламжыг бүрэн шинэчлэх зорилгоор 3 давхар цэвэрлэгээний цогц зураг гаргуулахаар хятадын KAIFENG AOHUA MASHINERY CO:LTD компаньд хүсэлт явуулаад байна.





**Бэлэн бүтээгдэхүүн хадгалах зорилгоор хуучин үйлдвэрийн дээвэр солих ажлыг эхлүүлэн, дээврийн дулаалга хэсгийг хуулж зөөвөрлөв**

**Нэмж цутгалт аван дээврийн хөрсний тэгшилгээ хийж бэлтгэн, цемэнтэн хучилт хийж гүйцэтгэв.**

**Төмөр дээвэртэй хэсгийн дээврийн модон болон төмөр хийцийг үйлдвэрийн ажилчдаар бүрэн сольж дуусгасан.**



Стандарт болон чанарын шаардлага хангасан 145ш поддоныг 5см банзаар хийж гүйцэтгэв. Мөн 500ш поддон нэмж хийхээр төлөвлөж, модон материалыг худалдаж авч бэлтгэсэн.



Үйлдвэрээс ашиглагдаад гарсан сэлбэг материалын актлаж устгалд оруулав.



Үйлдвэрийн халаалтын шугам эдэлгээ дуусаж, зэврэлтээс болж цоорсныг 100% шинчлэхээр материалыг татаж бэлэн болгон солих ажил 30% гүйцэтгэлтэй байна Шинээр баригдах агуулахын кадастрын зураг, ажлын зураг зэргийг гаргуулж ажиллав



Үйлдвэрт дагалдаж ирсэн болон суурилуулалтаас илүү гарсан сэлбэг бараа материалыг контейнерт нь тавиур угсарч эмхэлж цэгцлэв.




Шуудай сав баглаа боодлын MNS стандартын код тоо зөрүүтэй байсныг залруулж, шуудайны эхийг шинээр бэлтгэн БНХАУ-с захиалан үйлдвэрлэлд хэрэглэж байна.

## Шинээр 1кг-н савлагаа амжилттай нэвтэрлээ

“Хөвсгөл Алтандуулга” ХК нь бүтээгдэхүүний чанар, хэрэглэгчийн хэрэгцээнд нийцүүлэх зорилгоор 1 кг-ийн савлагааны автомат төхөөрөмжийг үйлдвэрлэлдээ амжилттай нэвтрүүллээ.

Тус төхөөрөмж нь бүтээгдэхүүнийг жигд жинтэй, стандартын шаардлага хангасан байдлаар савлах боломжтой бөгөөд жинлэх, уутлах, битүүмжлэх процессыг бүрэн автомат горимоор гүйцэтгэдэг.

Ингэснээр савлагааны алдаа багасч, бүтээгдэхүүний гадаад үзэмж, хадгалалтын чанар сайжирсан. 1 кг-ийн савлагааны автомат төхөөрөмжийг ашигласнаар гар ажиллагаа буурч, үйлдвэрлэлийн бүтээмж нэмэгдэн, ажилтнуудын хөдөлмөрийн аюулгүй байдал хангагдах нөхцөл бүрдэж байна. Мөн жижиглэнгийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, хэрэглэгчдэд илүү хүртээмжтэй бүтээгдэхүүнийг тогтмол нийлүүлэх боломжтой боллоо.

Бүхэл үрийн гурил, Дээд гурил, Нэгдүгээр гурилын 1кг савлагаа бүхий Бэлгийн багцыг шинээр худалдаанд гаргалаа.

## 1кг савлагааны машин















## Шинэ бүтээгдэхүүн

## ҮТРЭМ

1. Хаврын тариалалтын ажилд үрийн улаан буудай цэвэрлэх,  бордох ариутгах зэрэг ажлууд технологийн дагуу хийгдэв. Мөн ААН, хувь хүний үрийн улаан буудайг, ариутгах, бордох ажлыг давхар хийж гүйцэтгэлээ.
2. АА-н нэгж, Иргэдээс хүлээн авсан хүнсний улаан буудайг лаброторийн шинжилгээгээр ангилан талбайд байрлуулж цэвэрлэж, сортлон хадгалалтанд шилжүүлэв.









- Байгууллагын ерөнхий кадастрын зургийг мэргэжлийн байгууллагаар хийлгэж зургийг архивд шилжүүлэх ажлыг хийв.

- Хуучин агуулахад 240 тонн орчим хивэг хураав. Хураасан хивгийг ус бороонoос хамгаалж 3-н давхар хучлагаар хучив.

- Үйлдвэрээр хаврын тариалалтын үрийн буудайг бүрэн цэвэрлэж стандартад нийцүүлэн бэлтгэв.

- Боловсруулах үйлдвэр нь 1 ээлжээр хагас жилийн хугацаанд 1,816 тн улаанбуудайг тээрэмдэж олон нэр төрлын бүтээгдэхүүн болгон үйлдвэрлэж,хэрэглэгчдийн хэрэгцээ захиалгын дагуу савлаж бэлтгэн нийлүүлэв.Хэрэглэгчдийн захиалга нэмэгдсэнтэй холбогдуулан үйлдвэрлэлийг 2 ээлж болгон ажиллуулж нийт 7,341.92 тн улаан буудай тээрэмдэн олон нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэв.



# ХЯНАЛТЫН КАМЕР









- Нийт 16 хяналтын камерыг компанийн хашаа, үйлдвэрт нэмэлтээр суурилууллаа. Ингэснээр 2 байгууллагын хэмжээнд 28ш камер, дэлгүүрт 1 нийт 29 камераар 24 цагаар ажилчдын ажлын явцыг хянах, обектын аюулгүй байдлыг хянахад ашиглаж байна.



1. Бүтээгдэхүүнийг нийтэд танилцуулах, сурталчилгаа хийх ажилын хүрээнд Намнангийн ар, Их-Улын шил, Тосонцэнгэл сум, Мөрөн сумын газарт нийт 12ш самбарыг шинээр бэлтгэн байршуулав.










# СТРАТЕГИ ЗОРИЛТУУД

## Газар тариалангийн үйлдэрлэлийн чиглэлд

• Бага га-аас өндөр ургац авах. ОХУ-аас гарц өндөртэй, эрт болцын шинэ сортын үр тариаг туршилтаар тарихаар төлөвлөж байна.
• Хөрс хамгаалах, хөрсний үржил шимийг сайжруулах шинэ технологийг нэврүүлэх төлийн хүрээнд зөвлөмжийг хэрэгжүүлж, технологийг мөрдөж ажллана.
• Технологи нэвтрүүлэхтэй холбоотой техникийн шинэчилэлтийг хийнэ.
• Технологийн ажилд оролцогч оператор, агронамич нарын ажлын гүйцэтгэлийн чанар, үр дүнд тулгуурлан цалин хөлс, урамшуулалыг олгодог системийг бий болгон шинэчилэн ажиллана.
• Тариалалтын бүх талбайг хашаажуулж дуусгана.
• Компанийн хэмжээнд нэгжүүдийн уялдаа холбоог сайжруулах, үйл ажиллагааны болон санхүүгийн дотоод хяналтын системийг бүрдүүлж баг байгуулан ажиллана.
• Итгэмжлэгдсэн лабораторийг дахин итгэмжлүүлж, ургамал хорио цээрийн лабораторийн ажлын хүрээг өргөтгөн хүний нөөцийг чадавхижуулж ажиллах

## Гурилын үйлдвэрлэлийн чиглэлд

• Үйлдвэрлэлийн процессыг хагас автоматжсан горимд шилжүүлэх ажлыг санхүүгийн нөөц боломжинд тулгуурлан хэсэгчилэн шийдвэрлэж ажиллана.
• Үйлдвэрийн чанар, эрүүл ахуй, MNS ISO9001:2015 стандартыг бүрэн хангуулах, үйлдвэрлэлийн тогтвортой үйл ажиллагааг хагахад нийцүүлэн барихаар төлөвлөсөн Агуулахын өргөтгөлийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх, санхүүгийн эх үүсвэрийг олох
• Тэжээлийн үйлдвэрлэлийн орчин үеийн техник технологийг судлах, төсөл хөтөлбөр боловсруулах, хамрагдах, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах, бүс нутаг дахь малын тэжээлийн зах зээлд томоохон байр суурь эзлэх.

# БЭЛЭН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АГУУЛАХ















# Анхаарал хандуулсанд баярлалаа

Хөвсгөл аймаг, Тариалан сум, Мандал 1-р баг.
Утас: 70386030, 86050777, 98119703